

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянтээг ХК 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨВА-2023/12/НА-СТА-ОНА

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn
Арвайхээр хот	Аудитын менежер: Д.Гансүх Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com
2023 он	Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг Утас: 70323108 Цахим хаяг: Erdenetsetsegb@audit.gov.mn
	Аудитор: Э.Энхбаяр Утас: 70323833 Цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/



БАЯНТЭЭГ ХК-ИЙН ЗАХИРАЛ  
Ч.ГАНХУЯГ ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянтээг ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Баянтээг ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Баянтээг ХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүдийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан нь "Хязгаарлалттай" дүгнэлт өгөх үндэслэл болсон. Тухайлбал:

- Албан хэрэгцээнд 19.8 сая төгрөгийн суудлын автомашин худалдан авсан.
- Аймгийн ИТХ-аас баталсан Ерөнхий боловсролын болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш нарын ажлын амжилтыг үнэлж урамшуулах журмын хүрээнд 11ш зөврийн компьютер, 1ш IPAD нийт 26.2 сая төгрөгийн бараа худалдан авсан.
- Өв-Эко мийт ХХК-д хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол болон ТУЗ-ийн шийдвэргүй, батлан даагчийн гэрээгүй, зээлдэгчийн бизнес төлөвлөгөө байхгүй, гэрээнд гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангахын тулд барьцааны зүйл болгон эд хөрөнгийн барьцааг тусгаагүй зэрэг эрсдэл ихтэй 50.0 сая төгрөгийн зээл олгож авлагын дансанд бүртгэсэн.
- Эрч хүч хөгжил ХХК-тай 2021 оны 4 дүгээр сарын 26 өдрийн ӨВАОНӨГ/202103042 дугаартай дизель түлш нийлүүлэх гэрээний 4.3-т "захиралч шатахуун хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор үнийг төлж барагдуулах" гэж заасныг зөрчин 136.8 сая төгрөгийг урьдчилан төлж авлагын дансанд бүртгэсэн.
- Конторын барилгын засварын ажлыг хийлгэхдээ засварын ажлын төсөв батлуулаагүй, засварын ажил гүйцэтгэх гэрээ хийгдээгүй, засварын ажлыг хийж гүйцэтгэсэн, хүлээн авсан акт байхгүй, 19.3 сая төгрөгийн и-баримт зэрэг анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ бүртгэн шилжүүлсэн зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-

д "төсвийг зохистой удирдаж авлага өр төлбөр үүсгэхгүй байх". Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх.", Компанийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 83.8-д "Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлж эзгээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна". Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6-д "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх.", 5.1-д "Улсын Их Хуралд ажлаа шүүд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно." заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Урт хугацаат өр төлбөр дансанд ЗГ-ын 2007 оны 81 тоот тогтоолоор баталсан "Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан зардлын нөхөн төлбөрийн хэмжээг тооцож, төлөх журам"-ын дагуу 2010 онд Ашигт Малтмалын газартай "Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан зардлыг нөхөн төлөх тухай №ХА3-2010-IX02/19 тоот гэрээний" гэдэгдэл төлбөр болох 771.4 сая төгрөгийн өр төлбөр байна. Дээрх өр төлбөрийн төлөлт хийгдээгүй нь 2014 онд тус гэрээнд нэмэлт өөрчлөлт орсноор 5 жилийн хугацааны турш төлбөрийг төлж бүтээгдэхүүн экспортлох, хүчин чадлаа нэмэгдүүлэх, үйлдвэр уурхайг өргөтгөж дуусах үед дахин гэрээнд өөрчлөлт оруулан төлбөрийг нэмэгдүүлэн төлөхөөр хоёр тал харилцан тохиролцсон байна.

Тус компани 2022 онд зөвлөх үйлчилгээний хүрээнд "ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ" Олон улсын аудитын компаниар 2016-2021 оны санхүүгийн тайланд аудитын ажил гүйцэтгүүлсэн, Хараат бус Аудиторууд, Нягтлан бодогчид, Захирлуудын холбоо ТББ-аар "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" боловсруулах ажлыг тус тус зохион байгуулж, тус бодлогын баримт бичгийг 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр шийдвэрлэжээ.

### **Аудитын гол асуудал**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

### **Бусад асуудлын хэсэг**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээжээ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар ч нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэл гаргах харгалзахгийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



О. БАТЖАРГАЛ

**Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31.
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>		
Эргэлтийн хөрөнгийн дүн	5,026,100.3	7,052,339.5
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,050,123.8	6,133,980.7
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>11,076,224.2</b>	<b>13,186,320.2</b>
Нийт өр төлбөрийн дүн	1,105,840.9	1,127,674.5
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	9,970,383.2	12,058,645.7
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>11,076,224.2</b>	<b>13,186,320.2</b>
<b>Санхүүгийн орлого үр дүнгийн тайлан</b>		
Борлуулалтын орлогын дүн	7,305,424.4	8,804,259.7
Борлуулалтын өртөг	4,561,445.4	4,681,669.6
<b>Нийт ашиг алдагдал</b>	<b>2,743,978.9</b>	<b>4,122,590.1</b>
Татварын дараахь ашиг алдагдал	1,618,339.5	2,539,834.1
<b>Орлогын нийт үр дүн</b>	<b>1,618,339.5</b>	<b>2,539,834.1</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>		
Залруулсан үлдэгдэл	8,352,043.7	9,970,383.2
Тайлант үеийн цэвэр ашиг	1,618,338.5	2,539,834.1
<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>9,970,383.2</b>	<b>12,058,645.6</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	7,955,483.9	9,721,154.9
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	5,989,230.4	8,615,544.6
<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>1,966,253.5</b>	<b>1,105,610.2</b>
<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>(1,035,395.0)</b>	<b>(1,191,686.7)</b>
<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	<b>(69,282.3)</b>	<b>(21,264.9)</b>
<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>861,575.2</b>	<b>(107,341.4)</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,282,800.4	3,144,375.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,144,375.6	3,037,034.2

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар 1 алдаа, 10 зөрчил илэрсэн.

**3.1 Төлбөрийн акт**

Аудитаар алдаа зөрчил илрээгүй

**3.2 Албан шаардлага**Илрүүлэлт:

1. Тайлант онд албан хэрэгцээнд 19.8 сая тэгрэг суудлын автомашин худалдан авсан байна. Энэ нь төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 зүйлийн 4.2.6-д "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх," 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах," гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна

Шийдвэрлэлт:

Албан шаардлага

2. Аймгийн ИТХ-аас батлагдсан Ерөнхий боловсролын болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш нарын ажлын амжилтыг үнэлж урамшуулах журмын

хүрээнд 11ш зөөврийн компьютер, 1ш IPAD нийт 26.2 сая төгрөгийн бараа худалдан авсан байна. Энэ нь төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 зүйлийн 4.2.6-д "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх," 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах," гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна

Шийдвэрлэлт:

Албан шаардлага

3. Баянтээг ХК нь Өв-Эко мийт ХХК-д хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол болон ТУЗ-ийн шийдвэргүй 50000.0 мянган төгрөгийн зээл олгож авлагаар бүртгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д " төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.8-д "Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна."-гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэлт:

Албан шаардлага

4. Баянтээг ХК нь Эрч хүч хөгжил ХХК-тай байгуулсан гэрээний 4.5-т "цахилгаан шатрууан хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор үнийг төлж баралдуулах" гэж заасныг зөрчин 136.8 сая төгрөгийг урьдчилан төлж авлагын дансанд бүртгэсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д " төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.8-д "Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна."- гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэлт:

Албан шаардлага

5. Тайлант онд Конторын барилгын засварын ажлыг хийж гүйцэтгэсэн, хүлээн авсан акт байхгүй, 19.3 сая төгрөгийн и-баримт зөвөг анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ бүртгэн шилжүүлсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт:

Албан шаардлага

6. Тайлант онд Шилэн дансны цахим хуудаст худалдан авалттай холбоотой 2,156.1 сая төгрөгийн 3 төрлийн мэдээлэл, 328.3 сая төгрөгийн төсвийг зарцуулахтай холбоотой 18 төрлийн шийдвэрийг "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 7,10 дугаар хавсралтад заасан маягаар байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.3.-д тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон

шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;" 6.4.8-д " бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

#### Шийдвэрлэлт:

Албан шаардлага

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эзэмбелэн харуулав. Үүнд:

#### **1. Шийдвэр гаргалт, үйл ажиллагаатай холбоотой асуудал:**

##### Илрүүлэлт:

Баянтээг ХК -ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2022 оны 03 дугаар тогтоолороо тус компанийн 2022 оны нэгдсэн төлөвлөгөөг батлахдаа Нийгмийн өмнө хүлээх хариуцлагын хүрээнд хийх ажлын дээд хязгаар 145.6 сая төгрөг байхад 191.0 сая төгрөгөөр баталж 45.4 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Энэ нь Компанийн дүрмийн 7 зүйлийн 7.3.13<sup>1</sup>-д " Санхүүгийн жил дууссаны дараа, тухайн жилийн ашигт ажиллагааны түвшинг харгалзан компанийн цэвэр ашгийн 10 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөр орон нутаг (аймаг, сум)-т нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, уг хөрөнгө оруулалтын төрөл, хэмжээ, зарцуулалтад нь нийт ашгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчдийн саналыг төлөвлөлийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тусгаж хэрэгжүүлэх талаар шийдвэр гаргах;" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.13<sup>1</sup> дэх заалтыг мөрдөж амжилгах.

#### **2. Балансын данстай холбоотой асуудал:**

##### Илрүүлэлт:

Тайлант хугацааны эцэст ашиглалтад байгаа анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 102 ширхэг 579.6 сая төгрөгийн биет болон биет бус хөрөнгийн үнэ цэнийг тодорхойлоогүй, бодит үнэ цэнээр илэрхийлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 5.1.5."хэмжигдэхүйц байх" зарчмуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн биет болон биет бус хөрөнгүүд нь цаашид ашиглагдахаар бол үнэ шинэчлэн тогтоох, ашиглах жилийг уртасгах асуудлыг шийдвэрлэх

#### **3. Балансын данстай холбоотой асуудал:**

##### Илрүүлэлт:

Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 28 өдрийн 81 тоот тогтоолоор батлагдсан журмыг үндэслэн Баянтээгийн нүүрсний ордын эрэл, эрэл хайгуул, урьдчилсан хайгуул, нарийвчилсан хайгуулын ажлын зардлыг Улсын төсөвт эргүүлэн төлөх тухай Ашигт малтмал, газрын тосны газартай байгуулсан гэрээний үндэгдэл болох 771.4 сая төгрөг урт хугацаат өс төлбөрийн дансанд бүртгэлтэй, тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, бодит эрх нь нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "өд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнтэй шийдвэрлэх, бэлтгэн амлалтуудыг худалдан авагчтай

тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах, заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх, толилуулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Харилцагч байгууллагатай тооцоо нийлж өглөгийг баталгаажуулах, хэрэв гэрээний үүргээс чөлөөлөгдсөн бол тус өглөгийг тайлант хугацаанд орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгах, өглөгийн дансыг үнэн зөв илэрхийлэх;

**4. Зардлын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Байгууллагын зорилтот түвшний төлөвлөгөөнд тусгаагүй зардал, зөрчлөлтийн үр дүнг бууруулсан байна.

Энэ нь Компанийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.3.1-д "Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, тухайн жилийн бизнес төлөвлөгөө, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэр, үүрэг даалгаврыг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

1. Компанийн дүрэмд заасан үйл ажиллагааны зарчмын дагуу төлөвлөгдөөгүй зардлыг гаргахгүй байхад анхаарч, ажиллах;

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

(сая төгрөгөөр)

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан				Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Баянтээг ХК	1	666.7			1	666.7	1	666.7				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>666.7</b>			<b>1</b>	<b>666.7</b>	<b>1</b>	<b>666.7</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

(сая төгрөгөөр)

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт				Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Баянтээг ХК	9	1068.9			5	252.1	4	816.8				
<b>Дүн</b>	<b>9</b>	<b>1068.9</b>			<b>5</b>	<b>252.1</b>	<b>4</b>	<b>816.8</b>				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийтийн аудитын асуудал

Тоо, төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт	Албан шаардлага	Түнээс	Зөвлөмж
	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил	1	2484.4	1	2484.4		
Баянтээг ХК	1	2484.4		2484.4		
Дүн	1	2484.4		2484.4		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Дүн						
Нийт дүн	10	3553.3			2736.5	816.8

Тав. Төсвийн захирагчийн амлалтаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэвтрэл

№	Төсвийн захирагчийн амлалал	Байгууллага, нэгжийн тоо																		
		1	2	3	4	5	6	7	8	9	10									
А																				
1	ТШЗ																			
2	Төсөл, хөтөлбөр																			
3	ЗЛТС																			
4	ТТЗ																			
5	ТЭЗ																			
	НИЙТ																			

